

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ОРШИЛ.....	3
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
2.1. Төслийн нэр.....	4
2.2. Төсөл хэрэгжүүлэгч.....	4
2.3. Төслийн байршил	4
2.4. Уурхайн нөөц.....	8
2.5. Хүчин чадал	8
2.6. Уурхайн ажлын горим.....	8
2.7.Ашиглалтын систем.....	8
2.8.Уулын ажлын календарь төлөвлөлт.....	8
2.9. Ашиглалтын систем.....	9
2.10. Уурхайн тоног төхөөрөмжийн сонголт.....	9
2.11.Шимт хөрс хуулалт	10
2.12. Өрөмдлөг-тэсэлгээний ажил	10
2.13. Баяжуулах технологи	10
2.14. Хүний нөөц	10
2.15.Төслийн дэд бүтэц	10
БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН	12
ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	12
3.1.Физик газарзүй	12
3.2.Цаг уур амьсгал	12
3.3.Усан орчин.....	13
3.4.Хөрс	13
3.5.Ургамал	13
3.6.Амьтан	14
3.7.Нийгэм эдийн засгийн үзүүлэлт	14
БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	15
4.1.Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	15
4.2.Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	15
4.3.Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл	16
4.4.Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	16
4.5.Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл	16
4.6.Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл	17
4.7.Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	17
БҮЛЭГ 5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	18

БҮЛЭГ 6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20
6.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	20
6.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	23
6.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	23
6.4. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	23
6.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	24
6.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	24
6.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	25
6.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	26
6.9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	28
6.10. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө	30
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ...31	
ДҮГНЭЛТ	32
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	33

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	4
Хүснэгт 2. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн солбилцол	4
Хүснэгт 3. Газар эзэмших эрхтэй талбайнуудын солбилцол	5
Хүснэгт 4. Ил уурхайн уулын ажлын календарь төлөвлөгөө	8
Хүснэгт 5. Тоног төхөөрөмжийн жагсаалт	9
Хүснэгт 6. Орон тооны бүтэц	10
Хүснэгт 7. Барилга, байгууламжийн мэдээлэл	10
Хүснэгт 8. Төслийн нийт усны хэрэглээ	11
Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	20
Хүснэгт 10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	23
Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	24
Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	26
Хүснэгт 13. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	27
Хүснэгт 14. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөө	28
Хүснэгт 15. 2025 оны БОМТ-нд зарцуулах нийт зардал	29

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. “Эрээн”-ий төмрийн хүдрийн ордын байршлын зураг	5
Зураг 2. “Тайшэн девелопмент” ХХК-ийн эзмшлийн газрууд	6
Зураг 3. “Эрээн”-ий төмрийн хүдрийн ордын баяжуулах үйлдвэрийн харагдах байдал	7
Зураг 4. “Эрээн”-ий төмрийн хүдрийн ордын ил уурхайн харагдах байдал	7

БҮЛЭГ 1. ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Эрээн” нэртэй төмрийн хүдрийн орд төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

БОМТ-ний тайлан боловсруулах аргачлал:

Тус уурхайн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр		“Тайшэн Девелопмент” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар		9019007040
3	Уурхайн нэр		“Эрээн”-ий төмрийн хүдрийн орд
4	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Дундговь аймаг
5		Сум/Дүүрэг	Баянжаргалан
6	Ашигт малтмалын төрөл		Төмрийн хүдэр
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар		MV-017028
8	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар хот
9		Сум/Дүүрэг	Хан-уул дүүрэг
10		Баг/Хороо	11-р хороо
11	Захирлын хаяг	Нэр	Захирал
12		Гар утас	976-88003561

2.1. Төслийн нэр

“Эрээн”-ий төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төсөл

2.2. Төсөл хэрэгжүүлэгч

“Тайшэн Девелопмент” ХХК


2.3. Төслийн байршил

Эрээний төмрийн орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын төвөөс зүүн тийш 34 км-т, Чойр төмөр замын өртөөнөөс 48 км-т, Улаанбаатар хотоос зүүн урагш 280 км-т дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн районд байрлана.

Хүснэгт 2. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн солбилцол

Т.3 дугаар	Цэгийн дугаар	Газарзүйн солбицол						Га, талбай
		ӨРГӨРӨГ			УРТРАГ			
MV-017028	1.	45 ⁰	50'	51.61"	108 ⁰	15'	11.61"	326.44
	2.	45 ⁰	52'	1.61"	108 ⁰	15'	11.61"	
	3.	45 ⁰	52'	1.61"	108 ⁰	14'	1.62"	
	4.	45 ⁰	50'	51.61"	108 ⁰	14'	1.62"	

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Эрээн”-ий төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө



Зураг 1. “Эрээн”-ий төмрийн хүдрийн ордын байршлын зураг


“Эрээн”-ий ордын ойр орчимд “Тайшэн девелопмент” ХХК нь Баянжаргалан сумын Засаг даргын зөвшөөрлөөр 0340546 дугаар бүхий 102.6 га талбай, тэсрэх бодисын агуулах барих зориулалтаар 0340545 дугаар бүхий 5.6 га талбай, үйлдвэрийн зориулалтаар 0002464 дугаар бүхий 400 га талбай, хөрсний овоолго байруулах зорилгоор 0002483 дугаар бүхий 54.9 га талбайнуудын Газар ашиглах эрхийн гэрчилгээг эзэмшдэг байна (Зураг 2).

Хүснэгт 3. Газар эзэмших эрхтэй талбайнуудын солбилцол

Газрын гэрчилгээний дугаар	Цэгийн дугаар	Газарзүйн солбицол						Га, талбай
		УРТРАГ			ӨРГӨРӨГ			
Дугаар- 0340546	1	108	13	28.99	45	52	1.61	102.6
	2	108	14	1.61	45	52	1.61	
	3	108	14	1.61	45	51	30.1	
	4	108	13	52.4	45	51	30.1	
	5	108	13	52.4	45	51	8.28	
	6	108	13	29.0	45	51	8.28	
Дугаар- 0340545	1	108	15	38.9	45	50	57.7	5.6
	2	108	15	52.54	45	50	57.7	
	3	108	15	52.54	45	50	51.64	
	4	108	15	38.93	45	50	51.64	
Дугаар- 0002483	1	108	14	1.61	45	51	30.1	54.78
	2	108	13	52.4	45	51	30.1	
	3	108	13	52.4	45	51	8.27	

**Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Эрээн”-ий төмрийн хүдрийн ордыг
ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

	4	108	13	52.4	45	50	41.79	
	5	108	14	40.33	45	50	41.79	
	6	108	14	39.84	45	50	51.68	
	7	108	14	1.61	45	50	51.61	
Дугаар- 0002464	1	108	15	11.61	45	51	56.61	396.3
	2	108	15	41.61	45	51	56.61	
	3	108	15	41.61	45	52	31.61	
	4	108	16	51.52	45	52	31.61	
	5	108	16	51.62	45	51	21.61	
	6	108	15	11.61	45	51	21.61	
	1	108	15	57.65	45	51	21.61	38.75
	2	108	16	44.89	45	51	21.61	
	3	108	16	44.89	45	51	20.07	
	4	108	16	23.96	45	51	20.07	
	5	108	16	23.96	45	51	0.67	
	6	108	15	57.65	45	51	0.67	
	1	108	16	51.61	45	52	3.56	17.48
	2	108	17	0.6	45	52	3.56	
	3	108	17	0.6	45	51	34.37	
	4	108	16	51.61	45	51	34.37	



Зураг 2. "Тайшэн девелопмент" ХХК-ийн эзэмшлийн газрууд



Зураг 3. “Эрээн”-ий төмрийн хүдрийн ордын баяжуулах үйлдвэрийн харагдах байдал



Зураг 4. “Эрээн”-ий төмрийн хүдрийн ордын ил уурхайн харагдах байдал

2.4. Уурхайн нөөц

Ордын үйлдвэрлэлийн нөөц нь нийт магадласан В' зэрэглэлээр 78,847.4 мян.тн хүдэрт 33.54%-ийн агуулгатай 26,442.6 мян.тн хүдэр байна гэж үзсэн байна.

2.5. Хүчин чадал

“Тайшэн Девелопмент” ХХК нь жилд **$A_{ж}=1,000.0$ мян.тн** хүдэр баяжуулах хүчин чадалтай хуурай баяжуулах үйлдвэрийг барьсан бөгөөд төслийн хүчин чадал ашиглалтын эхний таван жилд **$A_{ж}=1,000.0$ мян.т/жил** хүдэр буюу нийт 5 жилийн хугацаанд 5 сая.тн хүдэр олборлон, хуурай соронзонгийн аргаар баяжуулна. Харин ашиглалтын 6 дахь жилээс нойтон баяжуулах үйлдвэрийг барьж, ашиглалтанд оруулахаар төлөвлөсөн бөгөөд нойтон баяжуулах үйлдвэр ашигтанд орсноор уурхайн жилийн хүчин чадал **$A_{ж}=5,000.0$ мян.т/жил** хүдэр болж өсөхөөр тооцсон байна.

2.6. Уурхайн ажлын горим

Эрээний уурхай нь жил бүрийн 1-р сарын 1-ээс 12-р сарын 31-ний хооронд ажиллах бөгөөд жилд ажиллах боломжит 365 хоногоос Монгол улсын хууль тогтоомжуудад заасны дагуу нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд заасны дагуу амралтын 16 хоног, цаг агаарын саатал 24 хоногийг хасч тооцсоноор уурхайн жилд ажиллах цэвэр хугацааг 325 хоног байхаар тооцсон байна.

2.7. Ашиглалтын систем

Ордыг ил аргаар, авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглахаар тооцжээ.

2.8. Уулын ажлын календарь төлөвлөлт

Эрээний хүдрийн ил уурхайн хүрээ хязгаарт багтаж буй эдийн засгийн хувьд үр ашигтай бодитой В зэрэглэлийн нөөц, олборлолтонд зайлшгүй өртөж буй боломжтой С зэрэглэлийн нөөцийг ил уурхайн төлөвлөсөн хүчин чадлаар ($Q_{жил}=1,000.0-5,000.0$ мян.т) олборлоход 20 жилийн хугацаанд ашиглах бөгөөд энэ хугацаанд нийт 28,467.3 мян.м³ хөрс хуулж, 78,847.4 мян.т хүдэрт 33.54%-ийн агуулгатай 26,442.6 мян.т металл олборлоно. Хөрс хуулалтын дундаж коэффициент ордын дунджаар $K_{хд}=0.4$ м³/т байна.

Хүснэгт 4. Ил уурхайн уулын ажлын календарь төлөвлөгөө

Ашиглалтын жилүүд	Хөрс хуулалт, мян.м ³	Үйлдвэрлэлийн нөөц			Кхд, м ³ /тн	Өссөн дүнгээр	
		Хүдэр, мян.тн	Агуулга, %	Металл, мян.тн		Хөрс хуулалт, мян.м ³	Хүдэр олборлолт, мян.т
1 дэх жил	219.7	1,213.9	32.6	395.6	0.2	219.7	1,213.9
2 дахь жил	508.7	1,042.6	32.0	334.0	0.5	728.4	2,256.5
3 дахь жил	550.5	936.7	31.1	291.0	0.6	1,278.9	3,193.2
4 дэх жил	577.7	1,313.2	32.6	427.9	0.4	1,856.6	4,506.4
5 дахь жил	564.4	1,178.1	33.6	395.9	0.5	2,421.0	5,684.5
6 дахь жил	2,504.4	4,313.7	32.4	1,397.3	0.6	4,925.4	9,998.2
7 дахь жил	2,472.7	5,065.6	32.6	1,652.0	0.5	7,398.1	15,063.8
8 дахь жил	2,479.4	5,029.0	33.5	1,683.1	0.5	9,877.5	20,092.8
9 дэх жил	2,469.3	5,048.6	33.2	1,677.1	0.5	12,346.8	25,141.4

**Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Эрээн”-ий төмрийн хүдрийн ордыг
ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

10 дахь жил	2,414.1	5,061.0	33.3	1,684.1	0.5	14,760.9	30,202.4
11 дэх жил	2,417.0	5,010.1	34.3	1,716.1	0.5	17,177.9	35,212.5
12 дахь жил	2,328.2	5,016.8	33.1	1,660.3	0.5	19,506.1	40,229.3
13 дахь жил	2,311.2	5,009.0	32.9	1,648.7	0.5	21,817.3	45,238.3
14 дэх жил	1,635.1	5,074.8	32.6	1,654.4	0.3	23,452.4	50,313.1
15 дахь жил	1,210.4	5,015.8	33.5	1,677.9	0.2	24,662.8	55,328.9
16 дахь жил	1,172.3	5,021.4	33.9	1,701.9	0.2	25,835.1	60,350.3
17 дахь жил	983.3	4,989.9	34.7	1,731.3	0.2	26,818.4	65,340.2
18 дахь жил	848.9	5,000.0	34.9	1,745.0	0.2	27,667.3	70,340.2
19 дэх жил	575.2	5,000.0	34.9	1,745.0	0.1	28,242.5	75,340.2
20 дахь жил	224.8	3,507.2	34.9	1,224.0	0.1	28,467.3	78,847.4
БҮГД	28,467.3	78,847.4	33.54	26,442.6	0.4	-	

2.9. Ашиглалтын систем

Ордыг ил аргаар нээж, ашиглах бөгөөд тэсэлгээтэй, авто тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглана.

2.10. Уурхайн тоног төхөөрөмжийн сонголт

Хүснэгт 5. Тоног төхөөрөмжийн жагсаалт

Техникийн төрөл	Тоног төхөөрөмжийн тоо	Түлш зарцуулалт, л/мото.цаг	Ээлжин дэх цэвэр ажлын цаг	Ээлжин дэх түлш зарцуулалт, л/ээлж
Өрмийн машин, компрессор				
SWDB-165	5	15	10	750
Экскаватор				
Hyundai R520LC	2	50	10	1000
Hyundai R850LC	3	55		
Автосамосвал				
ZZ5707V4048CJ	28	2.0	10	560
Бульдозер				
Shantui-SD23	3	60	10	1800
Дугуйт ачигч				
SL56H	2	30	10	600
877H	2	35	10	700
Автогрейдер				
XCMG-180HP	1	25	10	250
Ээлжинд зарцуулах түлш				5660
Түлшний машины багтаамж				5000

2.11. Шимт хөрс хуулалт

Шимт хөрсний гадаад овоолгыг 2 метрийн өндөртэй, 30 градусын налуутайгаар, үерийн ус болон салхины нөлөө бага байх газар байгуулахаар төлөвлөжээ.

Шимт хөрсийг хөрсний гадаад овоолгын суурийн талбайгаас 0.1 метрийн зузаантайгаар хуулах бөгөөд ашиглалтын хугацаанд 140.9 мян.м³ шимт хөрс хуулах ба сийрэгжилт тооцсоноор 155.0 мян.м³ шимт хөрсийг овоолгод овоолохоор тооцжээ.

2.12. Өрөмдлөг-тэсэлгээний ажил

Тэсэлгээний ажилд “эмульсийн” болон “энгийн найрлагат /анфо/” тэсрэх бодисыг нонель системийн тэсэлгээний иж бүрдэл хэрэгсэлтэй хослуулан хэрэглэхээр тоожээ. Ашиглалтын өмнөх жилүүдэд тус ордод эмульсийн болон анфо тэсрэх бодисыг нонель системийн тэсэлгээний иж бүрдэл хэрэгсэлтэй хослуулан хэрэглэж байсан байна.

Уурхайг түшиглэн 80 тн багтаамжтай тэсрэх бодис, 15-20 тн багтаамжтай тэсэлгээний хэрэгслийн агуулах баригдсан байна.

2.13. Баяжуулах технологи

Төслийн 6 дахь жилээс төмрийн хүдэр баяжуулах хуурай болон нойтон баяжуулах үйлдвэрүүд нь зэрэг ажиллах бөгөөд хуурай баяжуулах үйлдвэрээс гарсан төмрийн баяжмалыг нойтон баяжуулах үйлдвэрт тэжээл болгон өгөхөөр тооцсон. Өөрөөр хэлбэл хуурай баяжуулах үйлдвэр нь жилд 1.0 сая.тн хүдэр, нойтон баяжуулах үйлдвэр нь жилд 3.62-4.45 сая.тн хүдэр баяжуулах хүчин чадалтай байна.

2.14. Хүний нөөц

Хүснэгт 6. Орон тооны бүтэц

№	Орон тооны төрөл	1-5 дахь жил	6-20 дахь жил
1	ИТА	87	127
2	Оператор	51	174
3	Ажилчин	57	73
4	БТА	38	56
5	Нийт ажилчид	233	430

Нийт ажилчдаас уурхайн захиргаа, удирдлагын хэсэгт 16 хүн, уурлын хэсэгт 92-182 хүн, баяжуулах хэсэгт 43-124 хүн, засвар механикийн хэсэгт 44-52 хүн, аж ахуй үйлчилгээний хэсэгт 38-56 хүн, нийт 233-430 хүний ажлын байр бий болгохоор тусгагдсан байна.

2.15. Төслийн дэд бүтэц

Эрээний ордыг 2015 оноос олборлож эхлэсэн тул шаардлагатай дэд бүтэц болох уурхайн цахилгаан хангамж, ус хангамж, дулаан хангамж, хотхоны барилга болон гадаад,

**Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Эрээн”-ий төмрийн хүдрийн ордыг
ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

дотоод тээврийн зам, харилцаа холбоо зэргийг бүрэн шийдсэн байна. **Барилга байгууламж:**

Уурхайн кемп нь тусгай зөвшөөрлийн талбайн зүүн хойд хэсэгт ил уурхайн ухаашаас хамгийн ойрдоо 0.8 км зайд байрлана. Баяжуулах үйлдвэр, засварын төв нь уурхайн кемпийн урд хэсэгт, ШТС уурхайн кемпийн зүүн хойно 0.2 км зайтай байх бол тэсрэх материал, хэрэгслийн агуулах нь тусгай зөвшөөрлийн зүүн урд хэсэгт уурхайгаас хамгийн ойрдоо 1.5 км зайд байрладаг байна.

Хүснэгт 7. Барилга, байгууламжийн мэдээлэл

№	Барилгын нэр	Тоо ширхэг	Талбайн хэмжээ, м ²	Нийт талбай, м ²	Зориулалт	Бүтээц эдлэл
Хотхон						
1	Зөөврийн сууц-1	2	20	40	Уурхайн удирдлагын байр	Сэндвич
2	Зөөврийн сууц-2	1	80	80	Гал тогоо	Сэндвич
3	Зөөврийн сууц-3	1	60	60	Душ	Сэндвич
4	Зөөврийн сууц-4	15	100	1500	Ажилчдын амрах байр	Сэндвич
Ил уурхай						
5	Зөөврийн сууц-5	1	12	12	Харуулын байр	Сэндвич
6	Засварын талбай	1	50	50	Авто засварын төв	Шимт хөрсийг хуулж, талбайг тэгшилсэн
7	Түлшний ёмкост	1	15	15	Агуулах	Шимт хөрсийг хуулж, талбайг тэгшилсэн
8	Нийт	22	337	1757	-	-

Цахилгаан хангамж:

Гадаад цахилгаан хангамж: Эрээний уурхай нь Төвийн эрчим хүчний систем, “Багануур зүүн өмнөд бүс цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Говь-Сүмбэр аймгийн Чойр хот дахь 220/110/35/6 кВ-ын дэд станцаас уурхай хүртэл 55 км урттай 110 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам бүхий гадаад цахилгаан хангамжтай байна.

Дотоод цахилгаан хангамж: Харин уурхайн дотоод цахилгаан хангамжийн хувьд уурхайн цахилгаан хэрэглэгчид нь 6/0.4кВ-ын трансформаторын дэд станцаар дамжин дээрх шугамаар цахилгаан эрчим хүчээр хангагддаг байна. Одоо хангагдаж байгаа 6 кВ-ын агаарын шугам нь 0.68 км ба АС-50 маркийн утсаар холбогдсон ба 6/0.4 кВ-ын КТП-63 маркийн дэд станцтай байна.

Усан хангамж:

Уурхайн унд ахуй, үйлдвэрлэлд шаардлагатай усны хэрэглээг ордоос баруун урагш 4 км зайд **гүний худаг-1**, 6 км зайд **гүний худаг-2**-ыг тус тус өрөмдөж гарган, ус дамжуулах хоолойг татан усан хангамжийг бүрэн шийдвэрлэсэн байна.

**Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Эрээн”-ий төмрийн хүдрийн ордыг
ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Эхний 5 жилийн хугацаанд төмрийн хүдрийг хуурай аргаар угаан баяжуулах учраас технологид ус ашиглахааргүй байна.

Уурхайн усны хэрэглээг уурхай ашиглалтын эхний 5 жилээр тооцож гаргалаа.

Хүснэгт 8. Төслийн нийт усны хэрэглээ

Ажиллах хугацаа	Усны хэрэглээ					
Х.нэгж	Унд ахуйн ус, м³	Замын усалгаа, м³	Ногоон байгууламж, м³	Мод усалгаа, м³	Нийт	Шаардлагатай усны эх үүсвэр, л/с
1 дэх жил	6678.75	4,239.72	192.0	192.0	11302.47	0.402
2 дахь жил	6678.75	5,425.32	192.0	192.0	12488.07	0.444
3 дахь жил	6678.75	6,172.62	192.0	192.0	13235.37	0.471
4 дэх жил	6678.75	5,715.12	192.0	192.0	12777.87	0.455
5 дахь жил	6678.75	6,511.44	192.0	192.0	13574.19	0.483
Нийт	33,393.75	28,064.22	960.0	960.0	63,377.97	2.257

Уурхай ашиглалтын 5 жилийн хугацаанд нийт 63,377.97 м³ ус шаардлагатай бөгөөд 2.25 л/с усны ундрага шаардлагатай байгаа бөгөөд өөрийн эзэмшлийн 2 худаг (2.9 л/с) нь энэхүү шаардлагатай усны ундрагийн хэмжээг хангаж байна.

БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

3.1. Физик газарзүй

Дундговь аймаг нь Монгол орны физик-газарзүйн мужлалаар Говийн их мужийн Алтайн ар говийн мужийн Нууруудын хөндий тойрог, Хангайн өмнөд бэгэлцэгийн тойрог, Дорнод говийн мужийн Умарт талын гүвээт талын тойрог, Монголын Дорнод талын их мужийн Халхын Дундад ба Дарьгангын талархаг мужийн Ухаа Гүвээт Халхын дундад тал тойрогт багтаж байна.

Дундговь аймгийн Баянжаргалан сум нь Говийн их мужийн Дорнод говийн мужийн Умарт талын гүвээт талын тойрогт тус тус багтаж байна.

3.2. Цаг уур амьсгал

Дундговь аймгийн Баянжаргалан сум нь халуувтар зунтай, хуурайвтар мужид багтана.

Тус бүс нутаг нь эх газрын эрс тэс, хуурай уур амьсгалтай бөгөөд хоногийн болон сарын дундаж температурын хэлбэлзэл ихтэй байдаг байна. Хүйтний эрч 12, 1, 2-р сард

чангарч -15.3° - 32.6° , дунджаар -18.6° байдаг байна. Хөрсний хөлдөх гүн 3 метрээс хэтэрдэггүй бөгөөд дулааны дээд хэмжээ 6, 7, 8-р сард $+23^{\circ}$ $+30^{\circ}$ хүрдэг байна. Хаварын улиралд хүчтэй салхилах бөгөөд заримдаа цасан ба шороон шуурга болно. Салхины голлох чиглэл нь баруун хойд зүгээс болон хойд зүгээс өмнө зүгрүү чиглэлтэй байна. Жилийн хур тунадасны хэмжээ 110-340 мм хүрэх ба ихэнх нь зуны улиралд унадаг.

3.3.Усан орчин

Дундговь аймгийн нутаг дэвсгэр нь ус зүйн хагалбараар Номхон далайн ай савд багтана. Дундговь аймаг нь Умард голын гүвээт-Халхын дундад талын ай сав бүсэд хамаарна.

Эрээний ордын ойр орчимд нилээд хэдэн тооны худаг болон булгаас эх авч тэжээгддэг жижиг горхиуд бий. Ордын зүүн өмнөд хэсэгт орших Тогоо, Сэрвэнгийн булаг нь 720-1800 л/цаг ундрагатай байдаг. Эрээний ордын район дахь Билүүт, Эрээний шанд зэрэг худгууд нь томоохонд орно. Булаг нь боржингийн массиваас эх авч 2-3 км үргэлжлэн урсаж элсэнд шингэж алга болдог байна. Зун, намарын улиралд аадар борооны дараа гольдрол дагасан ус хуурай сайраар үерлэн урсана. Дээр дурьдсан худгуудын зарим нь булагдсан учир ашиглагддаггүй бөгөөд цөөн тооны худгийн усыг ундны хэрэгцээнд хэрэглэнэ. Үүний нэг нь Эрээн-шандын худаг юм. Нутгийн оршин суугчид ба мал аж ахуй ундны усаар тийм их хангалттай бус юм.

Эрээний төмрийн орд нь 15-25 м харьцангуй өндөртэй жижиг толгод дамнан байрладаг ба хайгуулын ажлын явцад малтсан суваг, өрмийн цооногуудад гадаргуугаас 280 м гүнд уст давхрага илрээгүй гэж ТЭЗҮ-д тусгагдсан байна.

3.4.Хөрс

Дундговь аймаг нь хөрс, газар зүйн мужлалтаар Монгол орны Говийн их мужийн өргөрөгийн бүсчилийн цайвар хүрэн хөрсний дэд бүсийн Дундговийн 7-р тойрог, Баяндэлгэрийн 8-р тойргуудын зааг хэсэгт хамрагдана.

“Эрээн”-ий төмрийн хүдрийн ордыг ашиглах талбайд сайргархаг хүрэн ба сайргархаг нимгэн хүрэн хөрсний хэв шинж тархаж байна.

3.5.Ургамал

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Эрээн”-ий төмрийн хүдрийн ордны газар нутгийн ургамал газарзүйн мужлалын хувьд Евроазийн хээрийн их муж Дагуур-Монголын дэд их муж Говийн умард-Дорнод хамаарна.(Үндэсний атлас, 1990). Бэлчээрийн ургамлан нөмрөгт судалгаа хийж, газрын төлөв байдал, ургамалжлын хэв шинжүүдийг тогтоох бичиглэл хийсэн. Төслийн талбайн геоморфологийн мужлалтаар нь Төв азийн геоморфологийн их муж, дэд муж Дундговьд хамаарна.

Уурхайн талбайд Хялгана-хазаар өвст, Жижиг бутат үетэн-алаг өвс агьт, Монгол өвсхазаар өвст-Хазаарөвс-Монгол өвс ургамлын бүлгэмдэл тархсан байна.

Судалгааны талбайн нь цөлөрхөг хээрийн бэлчээр бөгөөд 1 бүлгэмдэлд 14 овгийн 34 төрлийн нийт 37 зүйл ургамал бүртгэгдсэн.

3.6.Амьтан

Дундговь аймаг нь амьтны аймгийн хувьд газарзүйн мужлалаар Хойд говийн тойрогт багтана.

Хөхтөн: Энд хээрийн экосистемийн үндсэн гишүүд болох үнэг, хярс, чоно зэрэг махчид, цагаан зээр байхаас гадна мөн говийн амьтны аймгийн зарим төлөөлөл илрэнэ. Бид 5 багийн 13 зүйл хөхтөн амьтан тэмдэглэлээ. Эдгээрээс цагаан зээр нь улирлын байдал, бэлчээрийн гарц даган нүүдэллэх байдалтай тохиолдоно.

Шувуу: Энэ нутагт жигүүртэн шувуудаас хадны тагтаа, ногтруу түгээмэл тохиолдоно. Энэ районы орнитоценозын гол цөмийг монгол болжмор, адууч чогчоохой, бүжимч чогчоохой, шоорон алаг болжмор, хээрийн бор шувуу, оронгийн бор шувуу, хадны бор шувуу, үнсэн дунхай, хар хэрээ, хөхвөр тагтаа, ногтруу, шилийн сар, сохор элээ гэх мэт хуурай тал хээр, говь цөлийн ус дутмаг нөхцөлд сайн зохицсон суурин юмуу өндөглөн зусдаг нүүдлийн болон экологийн уян хатан чанар ихтэй эврибионт зүйлүүд бүрдүүлнэ.

Мөлхөгчид: Энэ талбайн эргэн тойронд 3 зүйлийн гүрвэл (монгол гүрвэл, могой гүрвэл, цоохор хонин гүрвэл), 2 зүйлийн могой (бамбай хоншоорт могой, рашааны могой) тохиолдоно. Эдгээрээс могой гүрвэл, цоохор хонин гүрвэл гэсэн хоёр зүйл нь Монголын говь, цөлд амьдардаг хамгийн өргөн тархалттай, тоо толгойн өндөр нягтшил бүхий зүйлүүд юм (Rogovin нар, 2001; Тэрбиш, 2004).

3.7.Нийгэм эдийн засгийн үзүүлэлт

Хилийн тойрог нь 1230 км, нутгийн баруун цэг Гучингийн худгаас зүүн цэг Хөх дэл хүртэл 425 км, хойд цэг Уст хар толгойгоос урд цэг Өвөр цагаан дэрс хүртэл 283 км бүгд 74.7 мянган ам км нутаг дэвсгэртэй. Тэгш тал газрын хамгийн өндөр нь далайн түвшнээс дээш 1530 м, хамгийн нам нь 980 м өндөр өргөгдсөн, хамгийн өндөр Дэлгэрхангайн уул далайн түвшнээс дээш 1913 м өндөр өргөгдсөн байдаг.

Аймгийн нутаг тал хээр, говийн бүсэд, дэлхийн цагийн 6-р бүсэд багтдаг. Дундговь аймаг засаг захиргааны нэгж 15 сум, 68 багтай.

Баянжаргалан сум нь 1924 онд байгуулагдсан, хүн амын суурьшил сийрэг, 1 ам.км талбайд 0.2-0.6 хүн ноогдоно. 3 баг, 385 өрх, 1161 хүн амтай. Үүний 603 нь эмэгтэй, 558 нь эрэгтэй. 0-18 насны 425, хөдөлмөрийн насны 626 иргэн тус тус байна.

Шилийн гол баг: Эрээний уурхай нь тус багийн нутаг дэвсгэрт орших ба барихаар төлөвлөж буй замын трасс нь тус багийн нутаг дэвсгэрийг дайран өнгөрнө. Тус баг нь 2011 оны байдлаар 110 өрхийн 275 хүн амтай, 29249 толгой малтай. Сумын төвөөс зүүн зүгт 19 км-т Шилийн гол хэмээх газарт оршдог, 174.0 мянган га газар нутагтай. Хойд талаараа өөрийн аймгийн Цагаан дэлгэр, зүүн талаараа Говьсүмбэр аймгийн Шивээговь, Дорноговь аймгийн Даланжаргалан, урд талаараа Өндөршил сумдтай тус тус хиллэдэг.

БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн талбай нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт байрлах “Тайшэн Девелопмент” ХХК нь MV-017028 тоот тусгай зөвшөөрөл бүхий 326.44 га талбайтай Төмрийн хүрийн ордыг ил аргаар ашиглах төсөл хэрэгжүүлнэ.

4.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний үед тоосжилт үүсэх,
- Уурхайн олборлолт, овоолгын талбайгаас салхинд хийсэх тоос шороо агаарыг бохирдуулах,
- Уурхайн олборлолтын явцад хөрс хуулалт, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зэргээс үүдэн агаарт дэгдэх тоосжилтын хэмжээ ихсэх, ойр орчмын газарт бохирдсон агаар тархах,
- Уурхайн талбайд ажиллах тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн шаталтаас утаа, хөө тортог, хорт хийнүүд агаарт дэгдэх,
- Үүссэн тоосжилт, хорт хийн хэмжээ нь талбай дахь ажлын нөхцлийг муутгах улмаар ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх,
- Уурхайн үйл ажиллагаанаас үүссэн тоосжилт, хорт хий газарт бууж ургамлан бүрхэвч ба хөрсөнд нөлөөлөх,
- Тэсэлгээний үед үүсэх тоосжилтын нөлөө,
- Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээний нөлөөлөл,
- Хог хаягдлаас үүсэх эвгүй үнэр ордын агаарын орчныг бохирдуулна.

4.2. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- “Тайшэн Девелопмент” ХХК нь Эрээний ордод ашиглалтын үйл ажиллагааг 2015, 2017 онд явуулсан бөгөөд 2017 оноос хойш ашиглалтын үйл ажиллагаа огт явуулаагүй байна. Тус онуудад уурхайн дэд бүтцийн асуудлууд болох уурхайн цахилгаан хангамж, уурхайн усан хангамж, зам харилцаа, уурхайн кемьп болон хуурай баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжийг барьсан, хүний нөөцөөр бүрэн хангагдсан байна,

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Эрээн”-ий төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

- Төмрийн хүдрийн орд нь 20жилийн хугацаанд ашиглах бөгөөд энэ хугацаанд нийт 28,467.3 мян.м³ хөрс хуулж, 78,847.4 мян.тн хүдэрт 35.54%-ийн агуулгатай 26,442.6 мян.тн металл олборлоно,
- Олборлолтын явцад хоосон ухаш, овоолго нэмэгдэн үүсэж газрын хэвлий эвдэгдэх,
- Уурхайн олборлолтын үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зэргээс үүдэн газрын гадарга элэгдэл эвдрэлд өртөх,
- Олборлолтын явцад тоосжилт үүсэх, хөрс элэгдэл эвдрэлд орох зэргээр газрын гадаргад өөрчлөлт орно,
- Тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөнөөс үүдэн газрын гадаргад өөрчлөлт орох.

4.3. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Төмрийн хүдрийн орд нь унд ахуй, зам усалгаа, технологийн ус, ногоон байгууламжийн усалгааг өөрийн эзэмшлийн гүний худгийн усыг ашиглах учраас гүний усны нөөцийн хомсдол үүснэ,
- Гүний худгийн ус бохирдох,
- ШТМ-ын асгаралт болон хог хаягдлын нөлөөгөөр гүний ус бохирдох,
- Төмрийн хүдрийн ордын эргэн тойронд үер усны аюулаас үүсэх нөлөөлөл, - Уурхайн талбайд ахуйн бохир усыг ил задгай асгаснаас үүдэн орчны бохирдол үүсэх, - Хаягдал усан сангийн ус хальж, ойр орчныг бохирдуулах.

4.4. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Олборлолтын явцад хөрс их хэмжээгээр эвдрэх, үүний улмаас хөрсний морфологи болон физик шинж чанар алдагдаж хөрсний үржил шим буурах, ойр орчмын талбайн хөрс элэгдэл эвдрэлд өртөх,
- Тээвэрийн хэрэгслийн хөдөлгөөний үед олон салаа зам гаргаснаас хөрс элэгдэл эвдрэлд өртөх,
- Хүнд даацын машин механизм, түүний тээвэрлэлт, засвар үйлчилгээний улмаас шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулах, - Хог хаягдал уурхайн эргэн тойронд тархаснаас үүдэн орчин бохирдох.

4.5. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл

- Тоосжилт үүссэнээс ургамал ба ургамлын бүрхэвч тоосонд дарагдаж, үүнээс шалтгаалан навч гэрлийг шингээх нь буурч ургамлын фотосинтезийн бүтээмж доройтох болно,
- Уурхайн үйл ажиллагааны нөлөө болон олборлолтоос үүдэн ургамал бүрмөсөн устах, талхагдалд өртөх,

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Эрээн”-ий төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр олон салаа зам бий болсноор ургамлан нөмрөг талхагдалд өртөх,
- Орчны бохирдлын нөлөөгөөр ургамлан нөмрөгийн амьдрах орчныг доройтуулах, - Хатуу болон шингэн хог хаягдлаар уурхайн орчин бохирдох.

4.6.Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Уурхайн талбайг битүү хашаалсан байгаа учраас амьтны аймагт учруулах сөрөг нөлөөлөл бага байна,
- Тээврийн хэрэгслийн тээвэрлэлт, хөдөлгөөн ихсэх хэрээр зэрлэг амьтад дайжих, үргэх, байршил нь тогтворгүй болох эрсдэлтэй,
- Олборлолтын үйл ажиллагаанаас болон тээврийн хэрэгслийн дуу чимээнээс үүдэн мал амьтан үргэн дайжих,
- Олон салаа зам, овор ихтэй техник болон олборлолтын нөлөөгөөр тухайн уурхайн талбайн ойр орчмын жижиг хөхтний бүлгэмдэл дайжиж устана. Зарим зүйл хүнд ойромсог зүйлүүд тухайлбал элдэв зүйл чичүүл, гэрийн хулгана, мөн хэрээ гэх мэт шувууд олноор байрших, үржих эрсдэлтэй,
- Уурхайн ухаш хоосон орон зайд мал, амьтан унаж, бэртэх, - Хууль бус ан агнуур хийх.

4.7.Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

- Болзошгүй осол аваар, саатал, техник, технологийн шугам сүлжээний гэмтэл, гал усны гэнэтийн аюул учирч болзошгүй. Үйл ажиллагааны явцдаа техникийн аюулгүй байдал алдагдах, гэнэтийн осол гарснаас ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх аюул үүсэх,
- Уурхайн ажлын үед машин механизмын дуу чимээ, тоосжилт ихэссэнээс хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй,
- Ажилчид хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллаагүйгээс үүсэх нөлөөлөл,
- Ажлын байрны тоо нэмэгдсэнээр нийгэм эдийн засгийн хөгжилд эерэг нөлөөлөл үзүүлнэ.

БҮЛЭГ 5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“Тайшэн Девелопмент” ХХК-ийн “Эрээн” нэртэй төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэх ажлыг төлөвлөхөд байгаль орчны менежментийн төлөвлөгөө оршино.

“Эрээн” нэртэй төмрийн хүдрийн ордыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан.

Энэхүү БОМТ-нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслөөс байгаль орчинд учруулах гол сөрөг нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж түүнд шаардагдах хөрөнгө зардлыг тусгадаг.

“Тайшэн Девелопмент” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ны дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, тухайн жилийн БОМТг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 26,530.0 мян.төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан.

Хуулин дээрх шаардлагын дагуу “Эрээн” нэртэй төмрийн хүдрийн ордын үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт

**Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Эрээн”-ий төмрийн хүдрийн ордыг
ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсрууллаа.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлын гол зорилго нь “Эрээн” нэртэй төмрийн хүдрийн ордын үйл ажиллагааны бүхий л үе шатыг хамрах ба төслийн үйл ажиллагаанас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг болзошгүй гол нөлөөлөл болон цаашид учруулж болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

БҮЛЭГ 6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төгрөг	Тоо хэмжээ	Нийт зардал, төгрөг, / 2025 он /	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар									
1	-Уурхайн олборлолт, овоолго, тээвэрлэлтийн үед үүсэх тоосжилт, -Тэсэлгээний үед үүсэх тоосжилт, -Хуурайшилт ихтэй үед салхины нөлөөгөөр тоосжилт үүсэх, -Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс ялгарах хорт хий агаарын чанартсөргөөр нөлөөлөх чимээний нөлөлөл үүсэх	Салхи шуурга ихтэй үед тэсэлгээний үйл ажиллагаа явуулахгүй байх, тэсэлгээг тухайн үеийн салхины чиглэл, хурд гэх мэт цаг агаарын үзүүлэлттэй уялдуулан зохион байгуулах	Тэсэлгээ хийх газарт	-	-	-	Дотоод төлөвлөлтөөр	Тогтмол	-Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, -MNS 4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, -MNS 3383:1982. Агаар мандал. Бохирдуулагчийн эх үүсвэрийг тодорхойлох, -MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, -MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга.
2		Тээврийн хэрэгслийн орчны агаарт ялгаруулах ялгаралтыг багасгах үүднээс тэдгээр тээврийн хэрэгсэлд оношилгоо, засвар үйлчилгээг тогтмол хийх, техникийн үзлэгт оруулах.	Тээврийн хэрэгсэл	-	-	-	Дотоод төлөвлөлтөөр	Жилд 1 удаа	

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Эрээн”-ий төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Газрын гадарга, хөрсөн бүрхэвч									
1	- Уурхайд олборлолтын нөлөөгөөр газрын хэвлий эвдрэлд өртөх, -Тээврийн хэрэгслийн нөлөөгөөр олон салаа зам үүсч хөрс элэгдэл эвдрэлд өртөх, -ШТМ-ын асгаралтаас газрын гадарга хөрс бохирдох, -Хог хаягдлыг ил задгай хаяснаас уурхайн орчин бохирдох.	Уулын ажлыг ТЭЗҮ-д тусгагдсан уулын ажлын төлөвлөгөөний дагуу хийж явуулах	Уулын ажил	-	-	-	-	Тогтмол	-MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, - MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага, MNS 5914:2008 Уул уурхайн үйлдвэрлэлд өртөн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх техникийн шаардлага, -MNS 5918:2023 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага, -MNS 5916:2008, “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” -
2		Уурхайн олборлолт хийх үед өнгөн хөрсийг хуулан авах, хуулан авсан өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгалах.	Шимт хөрс	-	-	-	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
3		Шимт хөрсний овоолгыг салхинд тархахаас сэргийлж хамгаалах, ургамалжуулах	Шимт хөрс				3,000,000	Олборлолтын үед	
4		Тээврийн хэрэгслийг тогтсон нэг замын маршрутаар явуулах, замын тэмдэг тэмдэглэгээг байршуулах, нэмэгдүүлэх.	Тэмдэг тэмдэглэгээ	-	-	-	2,300,000	Уурхайн үйл ажиллагаа -ны эхэн үед	
5		Шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавьж ажиллах, шатах тослох материал алдагдсан тохиолдолд цаг тухай бүрт нь саармагжуулах арга хэмжээ авах, Автомашины засварын газрын зогсоолыг цементэн хучилттай болгох	ШТМ	-	-	-	- 7,000,000	Тухай бүрт	
6		Уурхайн талбайд хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, уурхайн орчны цэвэрлэгээг тогтмол хийх	Хог хаягдал	-	-	-	-	Тогтмол	
Усан орчин									

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Эрэн”-ий төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1	-Гүний худгийн усны хомсдол үүсэх,	Ус ашиглах дүгнэлтийг гаргуулж ажиллах, усны төлбөрийг цаг тухай бүрт төлөх	Усны хэрэглээ	-	-	-	610,000	Тогтмол	-Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль,
	Нийт зардал						12,910,000		

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Эрэн”-ий төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

6.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Уурхайн нөхөн сэргээлтийг уурхайн олборлолтын дараа 20 дахь жилээс эхлэн хийхээр ТЭЗҮ-д тусгагдсан байна. Уурхайн олборлолтоор 20 жилийн хугацаанд нийт 148 га талбай эвдрэлд өртөнө. Уурхайд нөхөн сэргээлтийг жил бүр хийх боломжгүй бөгөөд уурхайн хаалтын үе шатанд хийхээр ТЭЗҮ-д төлөвлөсөн байна.

Иймээс тухайн техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсаны дагуу нөхөн сэргээлт хийгдэхгүй.

6.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх газрыг Дундговь аймгийн Байгаль орчны газраас санал авсны үндсэн дээр дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэхээр санал, шийдвэрт хүрсэн. 2025 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

№	Дүйцүүлэн хамгаалах ажлын зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нийт зардал, төгрөг, / 2025 он /	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Дундговь аймгийн нутаг дэвсгэрт эвдэрч орхигдсон газарт техникийн нөхөн сэргээлт хийх.	-Сум орон нутагтай ярилцаж эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийх	-	6,000,000	2025 онд	-Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль,
2	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 200 ширхэг мод тарих	- Сум орон нутагтай ярилцаж 200 ширхэг мод тарих	-	2,000,000	2025 онд	- -Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, журам, стандартын дагуу
Дүйцүүлэн хамгаалах ажлын нийт зардал, төг				8,000,000		

6.4. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн эдэлбэр газар болон түүний ойр орчмын нөлөөллийн бүсэд айл өрх байхгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ хийгдэхгүй болно.

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Эрэн”-ий төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

6.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвор илрээгүй. Уурхайн үйл ажиллагааны явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлын яаралтайгаар зохион байгуулж ажиллана.

6.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

“Тайшэн Девелопмент” ХХК-ийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа саатах, ажиллагсадын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул аюулгүй ажиллагааг анхаарч ажиллах шаардлагатай.

Хүснэгт 10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт зардал, төг / 2025 он /	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Болзошгүй аюул, осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, -Галын гэнэтийн аюул үүсэх, -Ажилчид бэртэх, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хяналт тавьж байх /ажил эхлэхийн өмнө/	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	-	Тогтмол	-Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17) -MNS6010-2009 Гамшгийн холбогдолтой нэр томъёо, тодорхойлолт, ерөнхий анги, -MNS 5002 2000: Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй
2		Тогтмол нийт ажилчидад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	Ажилчдад	1,000,000	Жил бүр	
3		Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажиллуулах	Уурхайн ажилчид	Дотоод төлөвлөлтөөр	Жил бүр	
4		Гал унтраах хэрэгсэл, багажийг зохих газруудад байрлуулсан эсэхэд мөн галын аюулгүй байдлын хяналт тавьж ажиллах	Уурхайн кемп орчимд	1,800,000	2025 онд	
5		Ажилд гарахын өмнө ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Уурхайн удирдлага	-	Тогтмол	
6		Аваар, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх ажилчидад сургалт орох	Уурхайн удирдлага	Дотоод төлөвлөлтөөр	Тогтмол	

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Эрэн”-ий төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

7		Тэсрэх бодисыг зөв хаягжуулж, хадгалах горимын дагуу хадгалах	Тэсрэх бодисын агуулах	-	2025 онд	
Нийт зардал				2,800,000		

6.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

“Тайшэн Девелопмент” ХХК нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргатай хог хаягдлын гэрээ байгуулан ажиллана. Уурхайн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай.

Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Нийт зардал, төг /2025 он/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хог хаягдал	Уурхай орчимд хог хаягдлын зориулалтын сав байрлуулах, хог хаягдлын ангилан ялгалтанд тогтмол хяналт тавих	Хог хаягдал	1,000,000	Тухай бүрт сайжруулах	-Хог хаягдлын тухай хууль /2017.05.12/, -MNS 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага, -Ариун цэврийн тухай хууль, - Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль.
2		Ахуйн хог хаягдлыг тусгай нэг цэгт төвлөрүүлэх, салхинд тархахаас сэргийлж хашаажуулах	Хог хаягдлын цэг	1,000,000	2025 онд	
3		Хог хаягдлын гэрээ байгуулж, тухай бүрт тээвэрлүүлэх.	Хог хаягдал	400,000	2025 онд	
4		Хуванцар сав, шил, лааз гэх мэт хоёрдогч түүхий эд болдог хаягдлыг орон нутгийн түүхий эд авах цэгт тушааж байх.	Ахуйн бохир ус	-	Тогтмол	
5		Ажиллагсдын бие засах газар, бохирын цооногт ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх	Бие засах газар, бохирын цооног	400,000	Хуваарийн дагуу	
6	Аюултай хог хаягдал	Ашигласан шатах, тослох материалыг зориулалтын сав байрлуулж	ШТМ хадгалах сав, поошик	2,000,000	2025 онд	

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Эрэн”-ий төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

		хуримтлуулах, уурхайн орчинд асгарч алдагдахаас тухай бүр сэргийлэх, ШТМ алдагдахаас сэргийлэх түүнд хяналт тавин ажиллах, Аюултай хог хаягдал устгал хийдэг, боловсруулдаг үйлдвэртэй гэрээ хийж хаягдлыг өгөх				
		Хаягдал дугуй, төмрийн хаягдалыг цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт тушааж байх	Хаягдал дугуй, төмрийн хаягдал гэх мэт аюултай хог хаягдал	Дотоод төлөвлөлтөөр	2025 онд	
Нийт зардал				4,800,000		

6.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Эрэн” нэртэй төмрийн хүдрийн ордыг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүрт илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөр гэнэ.


2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож тусгана.

Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нийт зардал, төг / 2025 он /	Баримтлах стандарт, арга аргачлал
Агаарын чанар					
1	Агаарын тоосны шинжилгээ хийлгэх (TSP, PM _{2.5} PM ₁₀)	-Уурхай орчмоос - Овоолго орчмоос - Кэмп орчим	Жилд 2 удаа	480,000	- “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2016, -MNS 3383:1982. Агаар мандал. Бохирдуулагчийн эх үүсвэрийг тодорхойлох, - MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, -MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга
2	Агаарын бохирдлын цэгэн шинжилгээ хийлгэх. (Нүүрстөрөгчийн исэл,	-Уурхай орчимоос	Жилд 2 удаа		

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Эрэн”-ий төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	Азотын исэл, Хүхрийн давхар исэл)				
Хөрсний чанар					
1	Хөрсний химийн үзүүлэлт (рН, EC _{2.5} dS/m, P ₂ O ₅ , K ₂ O, CaCO ₃)	-Ил уурхай орчим, -Кемп орчим -Овоолго -Баяжуулах үйлдвэр	Жилд 2 удаа	400,000	- MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, -MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, -MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох арга, -MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага, -MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох.
2	Хөрсний хүнд металлын бохирдол тодорхойлох (Cr, Cd, Pb, Ni, Co)	-Ил уурхай орчим, -Кемп орчим -Шатах тослох материалын агуулах, -Тээвэрлэлтийн зам.	Жилд 2 удаа	328,400	
Усны чанар					
1	Усны химийн шинжилгээ	- Гүний 2 худаг - Цэвэршүүлсэн ус	Жилд 2 удаа	300,000	-MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага, -MNS 13.060.50 Усны чанарын стандарт, -MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл Усны түвшин (газрын гадаргаас ахуйн шаардлага, түүнд тавих хянал
2	Бохирдол усны шинжилгээг хийлгэх	- Ахуйн хэрэгэлээнээс гарч байгаа бохир усанд	Улиралд 1 удаа	611,600	
Ургамлан нөмрөг					
1	Ургамлын төрөл зүйл, ургамлан нөмрөгийн бүрхэц, ургамлын зүйлийн тоо, арви бүрхэц, бүлгэмдлийг тодорхойлох судалгаа хийх.	- Кэмп орчим - Ил уурхай - Баяжуулах үйлдвэр	Жилд 1 удаа	700,000	MNS5546: 2005 Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамл-ын талхагдлыг тогтоох ерөнхий шаардлага.
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлыг нийт зардлын дүн				2,820,000	



Зураг 5. Мониторингийн цэгийн байршил

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Эрэн”-ий төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

6.9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

“Тайшэн Девелопмент” ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн нь байгаль орчны асуудлыг хариуцан ажиллаж, БОХТ, БОХШХ-ийг хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүн, тайланг компаний удирдлага, байгаль орчныг хариуцсан бүх шатны төр, захиргааны байгууллагын өмнө хариуцан ажиллах үүрэг хүлээнэ.

Хүснэгт 13. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон Төсөв / 2025 он /	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 онд				
			5-6 сар	7-8 сар	9-19 сар		
1	Байгаль орчныг хамгаалах сургалтыг ажилчдад зохион байгуулах	600,000		+		Уурхайн удирдлага	Ажилчдад байгаль орчныг хамгаалах талаар мэдлэг олгох.
2	Ажиллагсадыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Үйл ажиллагааны зардалд орсон		+		Уурхайн удирдлага	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж байх шаардлагатай.
3	Орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, гэрээний дагуу хамтран ажиллах	Дотоод төлөвлөлтөөр	+	+	+	Уурхайн удирдлага	Орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан нягт хамтран ажиллах
Нийт зардал		1,000,000					

6.10. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө

" Тайшэн Девелопмент " ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага, нутгийн иргэдэд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ.

Хүснэгт 14. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөө

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд		Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Зохион байгуулах газар
Дундговь аймаг	Орон нутгийн байгаль орчны газар	Хуралд танилцуулах	БОМТ-ийн 2025 оны хэрэгжилтийн тайлан	11-р сарын 01-ний өдрийн дотор	Уурхайд
	БОУАӨЯ-ны ХБОБХГ	Уулзалт			БОУАӨЯны ХБОБХГ
Төрийн захиргааны төв байгууллага	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга	Тайлан, төлөвлөгөөг тайлан хэлбэрээр болон Файл хэлбэрээр	2025 оны БОМТ	12-р сарын 01-ний өдрийн дотор	Засаг даргын тамгын газарт

2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

“Тайшэн Девелопмент” ХХК-ийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг
БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ
боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

2025 онд БОМТ-нд нийт **32,430,000** сая.төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 15. 2025 оны БОМТ-нд зарцуулсан нийт зардал

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, 2025 он /төгрөг/
1	Байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	12,910,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	8,000,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	4,800,000
7	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,800,000
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	600,000
9	Олон нийтэд тайлагнах төлөвлөгөө	500,000
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2,820,000
Нийт дүн		32,430,000

ДҮГНЭЛТ

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Тайшэн Девелопмент” ХХКийн “Эрээн” нэртэй төмрийн хүдрийн ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг боловсруулж дараах дүгнэлтэд хүрлээ.

“Тайшэн Девелопмент” ХХК-ийн 2025 оны БОМТ-ний биелэлтийн тайланг БОАЖын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

Уг төслийн явцад байгаль экологийн унаган төрхийг хамгаалахын тулд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүн, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө зэргийг мөрдлөг болгон ажиллаж, 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу байгаль орчны арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

“Эрээн” нэртэй төмрийн хүдрийн ордын БОМТ-нд 2025 онд нийт 26,530,000 төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

“Тайшэн Девелопмент” ХХК нь БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх үүрэгтэй.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012 он
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар УБ 2010.
4. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын стандартуудын эмхтгэл УБ 2010.
5. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” БОАЖСайдын А/618 тоот тушаал, 2019 он.
6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, үнэлгээ аудитын журам, аргачлал 2014
7. Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших MV-017028 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Эрээн” нэртэй төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ, 2023 он
8. Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Эрээн” нэртэй төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2024 он
9. <http://www.legalinfo.mn//>
10. Arc GIS 10.5